

## Банкуудын зээлийн тайлан


2017 оны 1 дүгээр улирал

Банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 2.1 хувиар буюу 255.6 тэрбум төгрөгөөр өссөн бол өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар өсч 12.6 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс татан буугдсан<sup>1</sup> банкуудын зээлийг хасч тооцвол нийт үлдэгдэл 12.4 их наяд төгрөг байна.

Харин банкуудаас Монголын Ипотекийн Корпорацид шилжүүлсэн<sup>2</sup> зээлийн багцыг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.5 хувийн өсөлттэй байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл хэрэглээний, цалингийн болон тэтгэврийн зээл нийт зээлийн үлдэгдлийн 29.8 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбар<sup>3</sup> 15.7 хувь, худалдааны салбар 14.4 хувь, боловсруулах үйлдвэрлэл 10.6 хувь, барилгын салбар 9.6 хувь, уул уурхайн салбар 6.0 хувь, бусад салбарууд 13.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл



Зураг 2. Зээлийн үлдэгдэл /гол салбараар/



<sup>1</sup> Зоос, Хадгаламж банк.

<sup>2</sup> МИК-д шилжүүлсэн 2.2 их наяд төгрөгийн зээлийн дүн нь банкны салбарын үзүүлэлтээс хасагдаж, бусад санхүүгийн байгууллагын үзүүлэлтэд тусгагддаг.

<sup>3</sup> МИК-д шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг хассанаар




Шинээр олгосон зээлийг салбаруудаар авч звэл 1 их наяд 484.9 тэрбум төгрөг буюу 51.6 хувийг хэрэглээ, цалин, тэтгэвэрийн зээлд, 653.5 тэрбум төгрөг буюу 22.7 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 199.4 тэрбум төгрөг буюу 6.9 хувийг орон сууцны ипотекийн зээлд, 185.9 тэрбум төгрөг буюу 6.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 72.1 тэрбум төгрөг буюу 2.5 хувийг барилгын салбарт, 51.2 тэрбум төгрөг буюу 1.8 хувийг уул уурхайн салбарт тус тус олгожээ.


Тайлант улиралд олгосон зээлийн 46.2 хувийг 1 жил хүртэлх хугацаатай, 45.6 хувийг 1-5 жилийн хугацаатай, 8.2 хувийг 5 жилээс дээш хугацаатай олгосон бөгөөд, 1 хүртэл жилийн хугацаатай зээлийн хувийн жин өмнөх оны мөн үеэс 3.1 нэгж хувиар нэмэгдэж, 5-аас дээш жилийн хугацаатай зээлийн хувийн жин 3.1 нэгж хувиар буурсан бол 1-5 хүртэл жилийн хугацаатай зээлийн хувийн жинд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант улиралд 2 их наяд 467.8 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 11.1 хувь буюу 247.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн дүн юм. Нийт зээлийн үлдэгдлийн 84.0 хувь нь хугацаандаа байгаа зээл, 7.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 8.2 хувь нь чанаргүй зээл байна.


Зураг 5. Олгосон ба төлөгдсөн зээл



Зураг 6. Олгосон зээл /салбараар/




Зураг 7. Олгосон зээл /хугацааны ангиллаар/




Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 90.0 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 27.0 тэрбум төгрөгөөр өсч 989.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 16.6 тэрбум төгрөг буюу 1.6 хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 67.2 тэрбум төгрөг буюу 6.0 хувиар өсч 1 их наяд 30.9 тэрбум төгрөгт хүрчээ. Чанаргүй зээл өмнөх улирлаас буурсаныг салбараар задлан харвал мэдээлэл, холбооны салбарт 72.5 хувь, худалдааны салбарт 13.8 хувь, барилгын салбарт 9.5 хувь, хөдөө аж ахуйн салбарт 8.8 хувь, тээврийн салбарт 8.4 хувь, цахилгаан хийн хангамжийн салбарт 2.7 хувь, санхүү даатгалын салбарт 1 хувь тус тус буурчээ. Харин эрүүл мэндийн салбарт 81.3 хувь, боловсролын салбарт 22.0 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарт 29.6 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 12.3 хувь, уул уурхайн салбарт 0.1 хувиар өссөн байна. Татан буугдсан Зоос, Хадгаламж банкуудын чанаргүй зээлийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 6.6 хувь байна.

Гол салбарууд дахь чанаргүй зээлийн хувь хэмжээг /Зоос, Хадгаламж банкуудыг хассанаар/ авч үзвэл уул уурхайн олборлолтын салбарт 18.5 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 12.4 хувь, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 10.2 хувь, хөдөө аж ахуйн салбарт 6.0 хувь, барилгын салбарт 5.7 хувь байна. Харин хугацаа хэтэрсэн зээлийн хувьд уул уурхайн салбарт 52.9 хувь, барилгын салбарт 13.4 хувь, хөдөө аж ахуйн салбарт 8.3 хувь, боловсруулах салбарт 7.3 хувьтай байна.

Зураг 8. Чанаргүй зээлийн хэмжээ ба өөрчлөлт



Зураг 9. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/



Зураг 10. Нийт зээлд эзлэх эрсдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа




Нийт банкны салбарын чанаргүй зээлийн 25.7 хувийг худалдааны салбар, 22.0 хувийг уул уурхайн салбар, 16.1 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 7.1 хувийг барилгын салбар, 6.9 хувийг үл хөдлөх хөрөнгийн салбар, үлдсэн хувийг бусад салбаруудын чанаргүй зээл бүрдүүлж байна.

Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл гол салбаруудаас боловсрол, уул уурхай, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь харьцаа хүрэлцээтэй түвшинд байгаа бол эрүүл мэнд, худалдаа, санхүү, даатгалын салбар дахь уг харьцаа бага байна. /Зураг 10/


Хувийн хэвшил, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл банкны салбарын зээлийн 99.3 хувийг бүрдүүлжээ. Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 21.9 хувийг худалдааны салбарт, 19.0 хувийг боловсруулах үйлдвэрийн салбарт, 17.4 хувийг барилгын салбарт, 11.1 хувийг уул уурхайн салбарт, 30.6 хувийг бусад салбарт тус тус олгожээ.

Иргэдийн зээлийн үлдэгдлийн 56.6 хувийг цалингийн зээл, хадгаламж барьцаалсан зээл, картын зээл, тэтгэврийн зээл болон бусад хэрэгцээнд зориулсан зээл бүрдүүлж байгаа бол орон сууцны ипотекийн зээл (МИК-д шилжүүлсэн зээлийг оруулахгүйгээр) 31.7 хувийг, 6.1 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 5.6 хувийг бусад салбарт тус тус олгосон байна.


Зураг 11. Хувийн байгууллагын зээл



Зураг 12. Иргэдийн зээл



Зураг 13. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт




Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлт 3.0 хувьтай байгаа бол иргэдийн зээл 16.1 хувьтай байна. Өмнөх улирлын зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад иргэдийн зээл 3.2 нэгж хувиар өсөж, хувийн хэвшлийн зээл 0.6 нэгж хувиар буурсан байна. МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оноос 12.4 хувиар өссөн байна. Харин МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг хасч тооцвол иргэдийн зээл 16.1 хувиар өссөн байна. /Зураг 13/


Тухайн салбарт олгосон зээлийн үлдэгдлийг зээлдэгчдийнх нь тоонд харьцуулахад уул уурхайн салбар хамгийн өндөр (3 тэрбум 902 сая ₮) дүнтэй байгаа бол барилгын салбар (965 сая ₮), цахилгаан, хийн хангамжийн салбар (858.5 сая ₮) мэдээлэл холбоо (527.7 сая ₮) удаалж байна. Харин нийт зээлд өндөр хувь эзэлдэг худалдаа, орон сууцны ипотекийн зээлийн нэгж зээлийн хэмжээ тус бүр 81.7, 48.9 сая төгрөгийн хооронд байгаа бол хэрэглээний зээлийн хувьд хамгийн бага дүнтэй буюу 4.5 сая төгрөг байна.

Тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбар (22.6%), барилгын салбар (20.8%), хэрэглээний зээл (20.1%) болон худалдааны салбар (20.1%) нь өндөр хувьтай байгаа бол боловсруулах үйлдвэрлэл (19.5%), тээврийн (18.9%) салбарт олгосон зээлийн хүү харьцангуй бага байна. Банкуудын тайлант улиралд олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа<sup>5</sup> 17.5 сар байна.

Зураг 14. Нэгж зээлийн хэмжээ<sup>4</sup>



Зураг 15. Олгосон зээлийн хүү /салбараар/



<sup>4</sup> Уул уурхайн салбарыг тус дүрслэлд харуулаагүй

<sup>5</sup> Тайлант улиралд олгосон ОСИЗ-ийн жигнэсэн дундаж хугацааг хассанаар